БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Тэшиг сумын ЗДТГ-ЫН  2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код:** БУА-2020/77/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn
(Булган хот)
2020 он

Тэргүүлэх аудитор: Д.Анхбаяр
Утас: 70342580
Аудитын менежер:  Ж.Энхцоодол
Утас: 70342716
Ахлах аудитор:  П.Содном
Утас:  70342495

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

# Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |

# Агуулга

1 Аудитын гэрчилгээ
3

2 Аудитын тайлан
4

2.1 Оршил ....................4

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага ....................4

2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт....................5

2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин ....................5

2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ....................6

2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал ....................6

2.7 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар ....................6

2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн ....................7

2.8.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал…..8

2.9 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал ....................8

2.10 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга....................8

2.11. Шилэн дансны мэдээлэл....................9

2.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга ....................9

2.13 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл ....................9

3 Менежментийн захидал
9

4 Аудит хийсэн санхүүгийн тайлан
**Error! Bookmark not defined.**

# 1 Аудитын гэрчилгээ

# 2 Аудитын тайлан

## 2.1. Оршил

Тэшиг сумын ЗДТГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг ЗДТГ-ын дарга А.Эрдэнэдалай-д танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

## 2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020.01.29-наас 2020.02.03–ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020.02.03-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Булган аймгийн аудитын газар-ын П.Содном хариуцаж хэрэгжүүлэв.

Тэшиг сумын ЗДТГ 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Булган аймгийн аудитын газар-т 2020.01.24-ны өдрийн 03/35 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### 2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

### 2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго: Тэшиг сумын ЗДТГ нь төрийн үйлчилгээг иргэдэд тэгш хүртээмжтэй хүргэх эвсэг чадварлаг хамт олныг бүрдүүлэн орон нутгаа хөгжүүлэх нь гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ. гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2019 оны Төсвийн тухай хууль
- Төрийн албаны тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэн

### 2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах  гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Тэшиг сумын ЗДТГ санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “CTS” программ хангамж ашигладаг байна.

Дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд (/Дунд) гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт (Үр нөлөөтэй) гэж үзлээ.

### 2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад  бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 23 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 12 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

### 2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр *Нийт зардал*-ын *1* хувиар сонгов.

*Нийт зардал*-г материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь төсөвт байгууллага нь санхүүжилтийг батлагдсан төсвийн хүрээнд олгодог тул нийт зардлаас сонгох нь зүйтэй гэж үзсэн юм.

2019 оны *Нийт зардал* 6,787.04 мянган төгрөг бөгөөд түүний *1* хувь болох *6,787.04* мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг *1* хувиар тооцсон нь 1 холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

## 2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 4 чиглэлээр аудитын 18 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 5 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 16 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 1 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй
асуудлыг ангилсан байдал

(Мянган төгрөгөөр)

| № | Шийдэл | Тоо | Дүн | Тайлбар |
|---|---|---|---|---|
| 1 | Зөвлөмж өгсөн | 3 | 12.320.90 | |
| 2 | Төлбөрийн акт тогтоосон | 0 | 0.00 | |
| 3 | Албан шаардлага өгсөн | 1 | 0.00 | |
| 4 | Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн | 0 | 0.00 | |
| 5 | Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн | 0 | 0.00 | |
| | Дүн | 4 | 12.320.90 | |

### 2.8.1. Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

### 2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Байхгүй

### 2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2019 онд 341804.9 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 340419.7 мянган төгрөг буюу (99.5) хувьтай байгаа нь  шалтгаалжээ.

### 2.11. Шилэн дансны мэдээлэл

Тэшиг сумын ЗДТГ Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

### 2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2019 оны жилийн эцсийн байдлаар өмнөх онд түүвэрт хамрагдсан зөвлөмж өгөөгүй байна. хувьтай байна.

### 2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

## 3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

**Илрүүлэлт:** Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2.4 дэх "Энэ журмын 2.1.1, 2.1.2 дахь хэсэгт заасан хохирлыг арилгахтай холбогдсон арга хэмжээг санхүүжүүлэхэд зориулж нийт батлагдсан хөрөнгийн 30-аас доошгүй хувийг зарцуулах ба хохиролд зарцуулагдаагүй үлдэгдлийг сарын хуваариас тооцоолж Засаг даргын нөөцөд бэлэн байршуулсан байна." гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй, Засаг даргын нөөц хөрөнгөөс биеийн тамир уралдаан тэмцээн, тэмдэглэлт баярын үйл ажиллагаанд нийт 3922.0 мянган төгрөг зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6.4.1 дэх "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэсэн заалттай нийцэхгүй байна.

**Эрсдэл:** Хууль, журам зөрчигдөх, зориулалт бус зардал гарах

**Зөвлөмж:** Засаг даргын нөөц хөрөнгөөс зориулалт бус зардал гарч болзошгүй байгаад анхаарч ажиллах.

**Илрүүлэлт:** Бичиг хэргийн зардлаас принтер авахад 0.2, хичээл үйлдвэрлэлийн зардлаас томилолтод 95.0, принтер авахад 435.0 нийт 530.0 мянган төгрөгийг бүлэг хооронд шилжүүлэн зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16.5.5 дахь "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах," 6.4.1 дэх "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

**Эрсдэл:** НББ-ийн тухай хуулийн холбогдох дүрэм журам зөрчигдөх, тайлан тэнцэл буруу илэрхийлэгдэх

**Зөвлөмж:** Төсвийн төлөвлөлтийг бодитой тооцоо судалгаанд үндэслэн хийх, зардлыг батлагдсан төсвийн дагуу зарцуулах,

**Илрүүлэлт:** ЗДТГ-ын авлагын дансны 7868.9 мянган төгрөгийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй нь НББ-ийн тухай хуулийн 20.2.6 дахь "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

**Эрсдэл** Авлага барагдсанаар батлагдсан төсөв хэтрэх, өглөг үүсэж төсөв ачаалал өгөх

**Зөвлөмж:** Авлагын данс дахь үлдэгдлийг барагдуулах талаар ажил зохион байгуулах,.

Илрүүлэлт: НББ-ийн тухай хуулийн 18.2 дэх “Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана.” гэсэн заалтыг хэрэгжүүлэн ажиллаагүй бодлогын бичиг баримтгүй байна.

Зөвлөмж: Санхүүгийн мэдээллийг цуглуулж, баримтжуулж, бүртгэлд тусгаж, нэгтгэн дүгнэж, санхүүгийн тайлан бэлтгэж, толилуулахын тулд бүртгэл хөтлөлтөд ашиглах бүртгэлийн суурийг тодорхойлсон, нийтлэг мөрдөх хууль, стандарт, дүрэм, журамд нийцсэн заавар, аргачлалын дагуу бүртгэл хөтлөх бодлогын бичиг баримтыг боловсруулах.

## САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **46,610,803.63** | **35,527,303.63** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | - | - |
| **311** | **Кассанд байгаа бэлэн мөнгө** | - | - |
| 31110 | Төгрөг | | |
| 31120 | Гадаад валют | | |
| 31130 | Нэмэлт санхүүжилт | | |
| 31140 | Касс арилжааны банк | | |
| **33** | **АВЛАГА** | 7,868,992.63 | 7,868,992.63 |
| **335** | **Бусад авлага** | 7,868,992.63 | 7,868,992.63 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | | |
| 3352 | Хувь хүмүүсээс авах авлага | 7,868,992.63 | 7,868,992.63 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 38,741,811.00 | 27,658,311.00 |
| **351** | **Түүхий эд материал** | - | - |
| 35110 | Тусгай зориулалттай материал | | |
| 35130 | Эм боох материал | | |
| 35200 | Дуусаагүй үйлдвэрлэл | | |
| 35300 | Бэлэн бүтээгдэхүүн | | |
| **354** | **Хангамжийн материал** | 23,592,941.00 | 27,509,441.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | - | 240,000.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 22,754,441.00 | 27,269,441.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | - | - |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 838,500.00 | - |
| 35600 | Мал амьтад | 15,148,870.00 | 148,870.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,354,706,959.74** | **1,242,714,771.19** |
| **37** | **УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ** | - | - |
| **371** | **Урт хугацаат хадгаламж** | - | - |
| 37110 | Төгрөг | | |
| 37120 | Гадаад валют | | |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 1,354,706,959.74 | 1,242,714,771.19 |
| 391 | Газар | | |
| **392** | **Биет хөрөнгө** | 1,269,650,959.74 | 1,157,658,771.19 |

| | | | |
|---|---|---|---|
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 6,670,265,756.66 | 6,717,536,069.29 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (6,247,662,181.20) | (6,290,863,837.98) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 209,979,200.00 | 234,979,200.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (139,023,497.04) | (140,368,671.76) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 1,238,517,518.74 | 1,258,575,168.74 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (470,500,234.90) | (663,578,088.67) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 27,620,294.00 | 28,703,394.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (19,545,896.52) | (21,857,795.77) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | - | 36,000,000.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | - | (1,466,666.66) |
| 39216 | Дуусаагүй барилга, байгууламж | | |
| 39217 | Ном | | |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 85,056,000.00 | 85,056,000.00 |
| 39301 | Програм хангамж | 300,000.00 | 300,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (300,000.00) | (300,000.00) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 85,056,000.00 | 85,056,000.00 |
| 39304 | Хуримтлагдсан элэгдэл | | |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **1,401,317,763.37** | **1,278,242,074.82** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **23,612,944.00** | **206,604.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 23,612,944.00 | 206,604.00 |
| **413** | **Өглөг** | 23,612,944.00 | 206,604.00 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 6,444,000.00 | 206,604.00 |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | 12,380,944.00 | - |
| 41330 | Татаас, санхүүжилт, шилжүүлгийн өглөг | | |
| 41340 | Хөрөнгө бэлтгэхтэй холбогдсон өглөг | | |
| 41350 | Зээлийн хүүгийн өглөг | | |
| **4136** | **Бусад өглөг** | 4,788,000.00 | - |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | - | - |
| 41362 | Хувь хүмүүст төлөх өглөг | 4,788,000.00 | - |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **1,377,704,819.37** | **1,278,035,470.82** |

| | | | |
|---|---|---|---|
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 1,377,704,819.37 | 1,278,035,470.82 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 200,665,855.00 | 200,665,855.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 200,665,855.00 | 200,665,855.00 |
| 51102 | - хувийн | | |
| 51103 | - хувьцаат | | |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 162,357,204.71 | 62,687,856.16 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 162,357,204.71 | 162,357,204.71 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | (99,669,348.55) |
| 51230 | Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс | | |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 1,014,681,759.66 | 1,014,681,759.66 |
| 51400 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | | |
| 51500 | Бодлогын өөрчлөлт алдааны залруулга | | |
| 51600 | Нөөцийн сан | | |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **1,401,317,763.37** | **1,278,242,074.82** |

**САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН**

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **294,608,621.00** | **579,034,697.47** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **-** | **139,457,547.47** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | - | 139,457,547.47 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | - | 139,457,547.47 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | 457,800.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | | |
| 1200043 | Урьд оны үлдэгдэлээс санхүүжих | | |
| 1200044 | Гадаадын эх үүсвэрээс санхүүжих | | |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | - | 138,999,747.47 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **294,608,621.00** | **439,577,150.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 294,290,221.00 | - |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 241,796,121.00 | |

| | | | |
|---|---|---|---|
| 131002 | Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт | 20,000,000.00 | |
| 131003 | Төвлөрүүлэх шилжүүлэг | | |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 32,494,100.00 | |
| 131008 | Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих | | |
| 131009 | Оны эхний үлдэгдлээс санхүүжих | | |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 318,400.00 | 97,772,180.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | | |
| 131102 | Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл | | |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 85,994,800.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 10,812,380.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 318,400.00 | 965,000.00 |
| 131106 | Төсвийн урамшуулал | | |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | - | 341,804,970.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | - | 341,804,970.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **568,489,819.16** | **678,704,046.02** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **568,489,819.16** | **678,704,046.02** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 568,489,819.16 | 678,704,046.02 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 177,084,606.00 | 184,605,948.00 |
| 210101 | Үндсэн цалин | 142,654,519.00 | 144,373,755.00 |
| 210102 | Нэмэгдэл | 32,645,087.00 | 31,870,093.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | | |
| 210104 | Урамшуулал | | |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 1,785,000.00 | 8,362,100.00 |
| 210106 | Ажиллагчдад төлсөн /ТӨҮГ/ | | |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 26,178,655.00 | 25,245,306.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 19,034,255.00 | 17,200,306.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,750,700.00 | 1,996,100.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,464,300.00 | 1,596,800.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 357,200.00 | 399,100.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,572,200.00 | 4,053,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210206 | Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/ | | |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 20,307,168.00 | 37,175,356.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,941,013.00 | 2,486,852.00 |
| 210302 | Түлш, халаалт | 15,527,159.00 | 33,491,500.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,838,996.00 | 1,197,004.00 |
| 210304 | Байрны түрээс | | |
| 210305 | Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/ | | |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 12,967,170.00 | 32,661,590.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,607,520.00 | 3,414,180.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 8,903,900.00 | 26,917,410.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,344,300.00 | 2,330,000.00 |
| 210404 | Ном, хэвлэл | | |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | | |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 111,450.00 | |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | | |
| 210408 | Бараа материал акталсны зардал | | |
| 210409 | Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн /ТӨҮГ/ | | |
| 210410 | Бараа материал худалдан авахад төлсөн /ТӨҮГ/ | | |
| **2105** | **Нормативт зардал** | 100,000.00 | - |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | | |
| 210502 | Хоол, хүнс | | |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 100,000.00 | - |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 955,716.00 | 3,359,765.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 25,000.00 | 1,393,400.00 |
| 210602 | Тавилга | | |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | | |
| 210604 | Урсгал засвар | 930,716.00 | 1,966,365.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 4,991,000.00 | 18,155,800.00 |
| 210701 | Гадаад албан томилолт | | |
| 210702 | Дотоод албан томилолт | 4,991,000.00 | 18,155,800.00 |
| 210703 | Зочин төлөөлөгч хүлээн авах | | |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,225,350.00 | 6,563,360.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 864,000.00 | 6,058,800.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 86,400.00 | 120,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 274,950.00 | 178,560.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | - | 176,000.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | - | 30,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 324,680,154.16 | 370,936,921.02 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 58,358,400.00 | 104,602,235.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 320,000.00 | 3,520,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 266,001,754.16 | 262,814,686.02 |
| 210904 | Найдваргүй авлагын алдагдал | | |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **(273,881,198.16)** | **(99,669,348.55)** |
| **145** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН** | | |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 302,198,689.09 | - |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | | |
| 225002 | Найдваргүй авлагын алдагдал | | |
| 225003 | Хөрөнгө оруулалтын гарз | | |
| 225004 | Гадаад валютын ханшийн зөрүүний гарз | | |
| 225005 | Үнэ төлбөргүй гарсан зардал | | |
| 225006 | Гадаадын төслийн зээлээс санхүүжих дамжуулан зээлдүүлэх | | |
| 225007 | Хөрөнгийн дахин үнэлгээний зардал | 302,198,689.09 | |
| 225008 | Дотоод эх үүсвэрээс олгосон зээл | | |
| 225009 | Дамжуулан зээлдүүлэх зээл | | |
| 230001 | Эргэж төлөгдөх зээл | | |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | (302,198,689.09) | - |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **(576,079,887.25)** | **(99,669,348.55)** |

**МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **294,608,621.00** | **440,034,950.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **318,400.00** | **457,800.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 318,400.00 | 457,800.00 |
| 120001 | Хувьцааны ногдол ашиг | | |
| 120002 | Хүүгийн орлого | | |
| 120003 | Торгуулийн орлого | | |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 318,400.00 | 457,800.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 318,400.00 | 457,800.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **294,608,621.00** | **439,577,150.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | | - |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 241,796,121.00 | |
| 131002 | Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт | 20,000,000.00 | |
| 131003 | Төвлөрүүлэх шилжүүлэг | | |
| 131004 | Төсөв болон дамжуулан зээлдүүлсэн зээлээс эргэж төлөгдөх | | |
| 131005 | Хөрөнгийн санхүүжилт | | |
| 131006 | Засгийн газрын тусгай сангаас санхүүжих | | |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 32,494,100.00 | |
| 131008 | Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих | | |
| 131009 | Оны эхний үлдэгдлээс санхүүжих | | |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 318,400.00 | 97,772,180.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 85,994,800.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 10,812,380.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 318,400.00 | 965,000.00 |
| 131106 | Төсвийн урамшуулал | | |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | - | 341,804,970.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | - | 341,804,970.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **294,608,621.00** | **428,212,200.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **294,608,621.00** | **428,212,200.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **294,608,621.00** | **428,212,200.00** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 174,836,006.00 | 190,733,344.00 |
| 210101 | Үндсэн цалин | 140,838,956.00 | 146,680,044.00 |
| 210102 | Нэмэгдэл | 32,212,050.00 | 35,691,200.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | | |
| 210104 | Урамшуулал | | |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 1,785,000.00 | 8,362,100.00 |
| 210106 | Ажиллагчдад төлсөн /ТӨҮГ/ | | |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 20,603,255.00 | 25,245,306.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210201 | Тэтгэврийн даатгал | 13,458,855.00 | 17,200,306.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,786,100.00 | 1,996,100.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,428,900.00 | 1,596,800.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 357,200.00 | 399,100.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,572,200.00 | 4,053,000.00 |
| 210206 | Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/ | | |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 24,835,224.00 | 47,881,300.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,274,065.00 | 3,153,800.00 |
| 210302 | Түлш, халаалт | 22,561,159.00 | 41,691,500.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | - | 3,036,000.00 |
| 210304 | Байрны түрээс | | |
| 210305 | Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/ | | |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 15,086,420.00 | 23,597,680.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,764,720.00 | 3,349,180.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 10,977,400.00 | 17,743,500.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,344,300.00 | 2,505,000.00 |
| 210404 | Ном, хэвлэл | | |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | | |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | | |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | | |
| 210408 | Бараа материал акталсны зардал | | |
| 210409 | Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн /ТӨҮГ/ | | |
| 210410 | Бараа материал худалдан авахад төлсөн /ТӨҮГ/ | | |
| **2105** | **Нормативт зардал** | 102,500.00 | 800,000.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | | |
| 210502 | Хоол, хүнс | | |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 102,500.00 | 800,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 960,916.00 | 5,798,700.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | - | 1,450,000.00 |
| 210602 | Тавилга | | |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | | |

| | | | |
|---|---|---|---|
| 210604 | Урсгал засвар | 960,916.00 | 4,348,700.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 2,976,000.00 | 19,830,800.00 |
| 210701 | Гадаад албан томилолт | | |
| 210702 | Дотоод албан томилолт | 2,976,000.00 | 19,830,800.00 |
| 210703 | Зочин төлөөлөгч хүлээн авах | | |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,943,850.00 | 8,258,540.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,582,500.00 | 7,753,980.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 86,400.00 | 120,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 274,950.00 | 178,560.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | - | 176,000.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | - | 30,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 53,264,450.00 | 106,066,530.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 52,865,950.00 | 102,301,530.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 398,500.00 | 3,765,000.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **-** | **11,822,750.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **-** | **11,822,750.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **-** | **11,822,750.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | - | 11,822,750.00 |
| 220001 | Барилга байгууламж | | |
| 221001 | Их засвар | | |
| 222001 | Тоног төхөөрөмж | - | 11,822,750.00 |
| 223001 | Бусад хөрөнгө | | |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-** | **(11,822,750.00)** |
| | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **-** | **-** |
| **7** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **-** | **-** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | - | - |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | - |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | - | - |

# ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 200,665,855.00 | 1,014,681,759.66 | 162,357,204.71 | 1,377,704,819.37 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **200,665,855.00** | **1,014,681,759.66** | **162,357,204.71** | 1,377,704,819.37 |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | - | - | - | - |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | - | - | - | - |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | - |
| C07 | Тайлант үеийн үр дүн | - | - | - | - |
| C08 | **2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **200,665,855.00** | **1,014,681,759.66** | **162,357,204.71** | 1,377,704,819.37 |
| D01 | **2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **200,665,855.00** | **1,014,681,759.66** | **162,357,204.71** | 1,377,704,819.37 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **200,665,855.00** | **1,014,681,759.66** | **162,357,204.71** | 1,377,704,819.37 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | - | - | - | - |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | - | - | - | - |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | - |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | - | - | - | - |
| D08 | Тайлант үеийн үр дүн | - | - | (99,669,348.55) | (99,669,348.55) |
| D09 | **2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **200,665,855.00** | **1,014,681,759.66** | **62,687,856.16** | 1,278,035,470.82 |